



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1/74

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээ хийх журам"-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1 дүгээр багийн иргэн А.Эрдэнэхүүгийнд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр гал түймэр гарч, байшингийн дотор тал шатсан тул үнэлгээ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ж.Солонго (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц.Баатарсүрэн (Байгаль орчны асуудал

хариуцсан мэргэжилтэн)

Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)

Н.Отгонбаяр (Засаг даргын Тамгын газрын нярав)

2.Үнэлгээг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан үнэлж, тайланг харьяалах онцгой байдлын байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсэг (Д.Батчулуун)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ

